

Цаг уур, орчны шинжилгээний газраас 2022 оны жилийн эцсийн байдлаар зохион байгуулсан сургалтын тайлан

№	Сургалтын сэдэв	Сургалтад оролцогчид	Биелэлт
1	2	3	8
1	Удирдах ажилтны сургалт, семинар	Газрын харьяа төв, орон нутгийн дарга, захирал нар	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын Удирдах ажилтны зөвлөгөөн-2022 Улаанбаатар хотноо зохион байгуулагдлаа. Уг Зөвлөгөөн жил бүрийн эхний улиралд зохион байгууллагддаг бөгөөд ЦУОШГ-ын дарга, хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтэнүүд, харьяа байгууллагын дарга, захирал, нар оролцож, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын өнгөрсөн оны ажлын үр дүн болоод энэ жил хийж хэрэгжүүлэх зорилт, цаашид анхаарах асуудлын талаар хэлэлцүүлэг өрнүүллээ. Зөвлөгөөний төгсгөлд Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын 2021 оны шинжилгээний ажлын нэгдсэн дүнгээр шалгарсан тэргүүний салбар, нэгжүүдийг танилцуулж, шагнал гардууллаа. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын 2021 оны ажлаараа Ховд аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв 1 дүгээр байр, Увс аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв 2 дугаар байр, Хэнтий аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв 3 дугаар байр эзэлж, өргөмжлэл, үнэ бүхий шагнууллаа.
2	Төв, орон нутгийн синоптик инженерүүдийн сургалт	Төв, орон нутгийн синоптик инженерүүд	Нислэгийн цаг уурын төвөөс 2 жил тутамд зохион байгуулдаг Иргэний агаарын тээврийн нислэгт цаг уурын үйлчилгээ үзүүлдэг синоптик инженерүүдэд зориулсан давтан сургалтыг 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн 5 хоногийн хугацаатай батлагдсан хөтөлбөрийн дагуу GOOGLE MEETING программыг ашиглан цахимаар зохион байгуулсан.

3	Албан хаагчдад зориулсан сургалт	ЦУОШГ албан хаагчид	2022 оны жилийн эцсийн байдаар сургалт, семинарын төлөвлөгөөг батлуулж нийт 13 сургалт батлагдсанаас 5 сургалт зохион байгууллагдаж бусад сургалтын санхүүлжилт байхгүйн улмаас хойшлогдов. Сургалтуудыг цахимаар зохион байгууллах тал дээр ажиллаж зарим сургалтыг цахимаар зохион байгуулсан. Мөн тус газрын албан хаагчидыг бусад байгууллагын цахим болон танхимиын сургалтуудад хамруулж нийт цахимаар 150 албан хаагч суралцаж, танхимаар 25 албан хаагч суралцсан байна. Мөн 1-2 өдрийн болон цагийн сургалтуудад 60 албан хаагч давхардсан тоогоор хамрагдсан байна. Мөн нийт системийн хэмжээнд албан хаагчдадаа Хөдөлмөрийн тухай хуулиар цахимаар болон танхимаар 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр 4 цагийн сургалтыг мэргэжлийн багшаар хичээл оруулсан болно. 2 дугаар сарын 16-ны өдөр мөн нийт албан хаагчдад БОАЖЯ-ны байгууллагын эрчим хүч сэдэвт сургалтад хамруулав. Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног бүрийн Пүрэв гаргат зохион байгуулдаг 7:4:10 арга зүйн цахим сургалтад албан хаагчдаа тогтмол хамруулж байна. Мөн Удирдлагын академийн сургалтад 8 албан хаагч хамраад суралцаж байна.
4	Цаг уурын ажиглагч бэлтгэх сургалт	Газрын харьяа төв, орон нутгийн техникич нар	2022 оны 04 дүгээр сарын 04-27-ны өдрүүдэд Улаанбаатар хотод танхимаар зохион байгуулсан “Цаг уурын ажиглагчийн чадамж эзэмшүүлэх сургалт”-д 53 албан хаагч хамрагдаж, амжилттай төгсч “Цаг уурын ажиглагч”-ийн үнэмлэх олгов. Мөн 11 дүгээр сарын 1-25-ны өдрүүдэд 9 албан Цаг уурын ажиглагчийн чадамж эзэмшүүлэх сургалтад хамрагдаж нийт 62 албан хаагч амжилттай төгсөв.
5	Шалгалт тохируулгын ажилтаны сургалт СХҮТ-өөс эрх олгох сургалт	Багажийн инженерүүд	2022 оны 10 дугаар сарын 17-ноос 5 хоног Улаанбаатар хотод танхимаар 24 албан хаагч БОХЗТЛ болон Стандарт хэмжилзүйн газарт сургалтад хамрагдлаа.

Дарга

С.Энхтүвшин

Хянасан: Захиргаа, аудитын хэлтсийн дарга

Н.Галцог

Сургалтын тайлан бичсэн ЗАХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭНМ.Лхагвасүрэн

УХА0160